


МӨНГӨНИЙ ТОЙМ

/2014 оны 4 дүгээр сар/



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014						
	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар
Инфляци							
Улаанбаатар хотын инфляци							
сарын	1.3	1.3	1.8	1.7	1.0	0.5	0.8
оны эхнээс	9.0	10.3	12.3	1.7	2.8	3.3	4.1
жилийн	9.5	11.1	12.3	12.2	12.0	11.9	12.0
Суурь инфляци							
сарын	2.8	1.2	1.3	0.7	0.3	0.2	0.7
оны эхнээс	9.4	10.7	12.1	0.7	1.0	1.2	1.9
жилийн	9.4	11.0	12.1	12.6	13.1	12.6	13.1
Улсын инфляци							
сарын	1.4	1.3	1.3	1.7	0.9	0.8	1.0
оны эхнээс	9.7	11.1	12.5	1.7	2.7	3.5	4.6
жилийн	10.8	12.0	12.5	12.3	12.2	12.4	12.3
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр							
сарын өөрчлөлт, %	2.8	4.4	3.8	6.0	-1.8	1.0	2.6
жилийн өөрчлөлт, %	22.2	29.4	24.1	36.6	36.1	36.3	42.0
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр							
сарын өөрчлөлт, %	4.8	7.3	1.3	9.5	0.3	1.5	1.8
жилийн өөрчлөлт, %	22.0	32.8	27.5	40.0	40.6	43.8	51.5
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр							
сарын өөрчлөлт, %	-5.7	-2.5	4.6	6.3	-15.4	5.9	5.0
жилийн өөрчлөлт, %	14.9	11.3	1.5	20.5	12.0	16.5	10.8
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр							
сарын өөрчлөлт, %	-10.2	6.8	18.1	2.3	5.9	-0.1	-16.9
жилийн өөрчлөлт, %	23.1	26.9	54.0	54.3	37.9	26.7	4.0
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр							
сарын өөрчлөлт, %	3.3	3.2	-0.5	2.3	1.3	2.0	3.1
жилийн өөрчлөлт, %	53.0	57.6	54.1	54.3	55.6	54.0	51.0
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар							
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Анод, Зоос-ыг хассанаар)	5.34	5.29	5.26	5.28	5.36	5.22	5.25
Хуу							
Хадгаламжийн ЖДХ	12.2	12.3	12.1	12.2	12.2	12.2	12.2
Зээлийн ЖДХ*	18.8	17.3	17.4	18.9	18.4	19.7	19.4
Монголбанкны ҮГХ зээлийг оруулсан ЖДХ*	16.0	15.7	14.9	17.0	16.4	17.8	17.6
Ипотекийн зээлийн ЖДХ	9.60	9.70	9.90	9.79	9.90	9.90	9.80
ТБҮЦ-ны ЖДХ	10.5	10.5	10.5	10.5	10.6	10.6	1.6
Бодлогын хүү	10.50	10.50	10.50	10.50	10.50	10.50	1.50
БХЗ-ын ЖДХ	9.64	9.13	8.91	9.48	9.78	9.35	9.58

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сараас 1.0 хувь, оны эхнээс 4.6 хувь, өмнөх оны мөн үеэс 12.2 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.8 хувь, оны эхнээс 4.1 хувь, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 0.7 хувь, оны эхнээс 1.9 хувь, жилийн 13.1 хувь байв.

Тухайн сард талх, гурил, будааны үнэ 1.6 хувь, мах, махан бүтээгдэхүүний үнэ 0.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 5.6 хувь, бусад хүнснийх 1.3 хувиар өсч харин хүнсний ногоо 0.4 хувиар буурч хүнсний барааны бүлгийн үнэ 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.6 хувиар өссөн бөгөөд үүнээс согтууруулах ундаа, тамхины үнэ 2.9 хувь, хувцас, бөс бараа, гуталны бүлэг үнэ 0.3 хувь, эм тарианы үнэ 0.6 хувь, автомашины хөдөлгүүрийн тосны үнэ 6.9 хувь, нийтийн хоолны үйлчилгээ 1.6 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, сарын инфляцийн 55 хувийг хүнсний бараа (үүнээс, талх, гурил, будаа 26 хувь, мах 28.6 хувь, сүү, өндөг 43.5 хувь), 15.9 хувийг согтууруулах ундаа, тамхи, 4.4 хувийг хувцас, бөс бараа, гутал, 1.3 хувийг тээвэр, 6.7 хувийг нийтийн хоолны үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.



Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 113 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 52 бараа үйлчилгээнийх буурсан байна.

Жилийн инфляцид хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 9.3 хувь (жилийн өсөлтийн 25.6 хувь), боловсролын үйлчилгээ 28.4 хувь (жилийн өсөлтийн 13.9 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 12.3 хувь (жилийн өсөлтийн 13.4 хувь), согтууруулах ундаа, тамхи 14.9 хувь, хувцас, бөс бараа, гутал 16 хувь (жилийн өсөлтийн 5.7 хувь), гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 22.3 хувь (жилийн өсөлтийн 5.6 хувь), тээвэр 4.7 хувь (жилийн өсөлтийн 4.7 хувь), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 13.4 хувь (жилийн өсөлтийн 4.1 хувь), эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ 17.4 хувь (жилийн өсөлтийн 4.0 хувь), бусад бараа үйлчилгээ 25.2 хувиар (жилийн өсөлтийн 7 хувь) тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ 2.7 хувь, холбоо, шуудангийн үйлчилгээний үнэ 0.2 хувиар буурсан байна. Хүнсний барааны бүлгийн жилийн өсөлтийн 32.1 хувийг талх, гурилан бүтээгдэхүүн, 20.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 35 хувийг өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 2.6 хувь, оны эхнээс 7.9 хувь, өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар өсч 10203.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 56.3 хувийг төгрөгийн хадгаламж, 14.2 хувийг валютын хадгаламж, 12.3 хувийг төгрөгийн харилцах, 11.4 хувийг валютын харилцах, 5.8 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.




Ипотекийн хөтөлбөрийг мөнгөний нийлүүлэлтээс хасч тооцвол мөнгөний нийлүүлэлт 24.9-42.0 хувийн хооронд өсөхөөр байв.



Тайлант сард төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 16.3 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 3.0 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 17.8 нэгж хувиар нэмэгдэж харин гадаад валютын хадгаламжийнх 27.2 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 2.7 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 555.8 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 135.4 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 66.8 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 41.6 тэрбум төгрөгөөр өссөн бол гадаад валютын хадгаламж 545.7 тэрбум төгрөгөөр буурчээ.

Нийт мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 68.6 хувийг төгрөгийн хадгаламж, 14.0 хувийг гадаад валютын хадгаламж, 11.5 хувийг гадаад валютын харилцах, 3.9 хувийг төгрөгийн харилцах, 2.0 хувийг

хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 0.1 хувь буюу 10.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 53.1 хувь буюу 2493.6 тэрбум төгрөгөөр өсч 7192.8 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 38.9 хувь буюу 578.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 5.3 дахин их буюу 1678.3 тэрбум төгрөгөөр өсч 2067.8 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.6 хувь буюу 23.0 тэрбум төгрөгөөр буурч, харин өнгөрсөн оны мөн үеэс 12.0 хувь буюу 392.0 тэрбум төгрөгөөр өсч 3672.2 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 27.3 хувь буюу 545.7 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 41.1 хувь буюу 423.3 тэрбум төгрөгөөр өсч 1452.8 тэрбум төгрөг болжээ.



Нийт хадгаламжийн 79.8 хувь нь төгрөгийн, 20.2 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өссөн байна.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 35.4 хувь, өмнөх оны мөн үеэс 90.3 хувиар буурч 332.3 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх сараас 4.6 хувь, өмнөх оны мөн үеэс 2.6 дахин их өсч 9871.0 тэрбум төгрөг болов.



Нийт мөнгөний 3.3 хувь нь гадаад цэвэр активт, 96.7 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 16.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар өсч 2598.8 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 7.6 хувь буюу 41.6 тэрбум төгрөгөөр өссөн бол банкуудын касс 0.5 хувь буюу 1.2 тэрбум төгрөг, Төв банк дахь харилцах, хадгаламж 24.4 хувь буюу 569.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурч 67.7 хувь болсон бол, банкуудын кассын эзлэх хувь 0.5 нэгж хувиар өсч 9.5 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 1.5 нэгж хувиар өсч 22.8 хувь болсон байна.

¹Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө

Зээл

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд саарч өмнөх сараас 2.9 нэгж хувиар буурчээ.

Хадгаламжийн байгууллагуудаас ¹ олгосон зээл өмнөх сарынхаас 3.1 хувь буюу 356.8 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 51.0 хувь буюу 3966.7 тэрбум төгрөгөөр өсч 11.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2.7 хувь буюу 167.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 51.7 хувь буюу 2187.2 тэрбум төгрөгөөр өсч 6413.8 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 3.8 хувь буюу 190.2 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 49.7 хувь буюу 1741.5 тэрбум төгрөгөөр өсч 5245.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.



татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.


хувиар өсч жилийн 19.4 хувь, гадаад валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч жилийн 12.1 хувь болжээ.



Харилцахын жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 2.7 хувь, валютынх жилийн 1.7 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсч жилийн 12.2 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч жилийн 5.3 хувь болов.

Мөнгөний зах

2014 оны 4 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 499.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 9.58 хувь байна.



2014 оны 4 сарын 2-ны өдрөөс 4 сарын 29-ний өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 867.0 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 413.5 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 869.4 тэрбум төгрөг, валютын нөөцөд 955.6 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2014 оны 4 дүгээр сарын эцэст 1796.19 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 360.1 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1784.11 төгрөг байв.

